

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС


## ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны 27 дугаар тэмдэглэлд:

“ХИИ. ХЭЛЭЛЦСЭН нь: Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь: “Нүүрсний тээвэрлэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2017 оны 320 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцээд хуралдаан дээр гишүүдээс гаргасан саналыг тусган тогтоол гаргахаар тогтов.

Үүнтэй холбогдуулан нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагаанд Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм журам, холбогдох стандартыг мөрдүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ нарт даалгав.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР